



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 599

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11/08 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 17,000,000.00 (арван долоон сая) төгрөгийн балансын үнэ, 6,374,999.97 (зургаан сая гурван зуун далан дөрвөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий, Приус-30 маркийн 00-58 ДОУ улсын дугаар, ZVW305324288 арлын дугаартай автомашиныг Дорнод аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Гэрэлцэцэг, Дорнод аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, Дорнод аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Л.Эрдэнэбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

1370000005